



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Худалдан авах ажиллагаа

Худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг батлуулан 2018 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.

Аймгийн худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан 22 ажлаас 22 ажлын худалдан авалтыг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Эрүүл мэндийн яам, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам, Барилга хот байгуулалтын яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Зам тээврийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас эрх шилжиж ирсэн нийт 15 тендерийг зохион байгуулан 12 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 4 ажлыг тендерийг зарласан тендерийг үнэлэх шатандаа байна. Бусад байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 13 ажлын худалдан авалтыг зохион байгуулж нийт 50 ажлын худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

2019 онд нийт 50 ажлын **33.772.596.766** төгрөгийн худалдан авалт зохион байгуулж нийт **856.338.948** төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажилласан байна.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Завхан аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлд тусгагдсан /Төлөвлөгдсөн ажлын 60-аас доошгүй хувийг цахимаар хийсэн байна/ заалтыг хэрэгжүүлэн 2019 онд зохион байгуулсан **50** ажлаас **44** ажлын **/88%-ийг/** худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулан ажилласан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд /tender.gov.mn, zavkhan.gov.mn сайтуудад/ оруулан нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна.

Монгол улсын Сангийн яам, Тогтвортой амьжиргаа-3 төсөл, Боловсрол ТББ-тай хамтран 2019 оны 05 сарын 05-09-ний өдрүүдэд худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ гэрчилгээ олгох сургалтыг зохион байгуулж сум бүрээс 6 хүн /иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл, төрийн албан хаагчдын төлөөлөл/ нийт 150 албан хаагч амжилттай хамрагдсан. Сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнуудад цахим худалдан ажиллагааны талаар заавар зөвлөгөө өгч цахим худалдан авах ажиллагааны системд сумдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, үр дүнг оруулан, цахим хэлбэрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Өмч хөрөнгийн хүрээнд

Орон нутгийн өмчит 221 хуулийн этгээдийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон хөрөнгийн мэдээллийг нь холбогдох маягтуудын дагуу шалган авч нэгтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тушаасан.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу төрийн

болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, санхүүгийн тайланд тусгах, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулж орон нутгийн өмчит нийт 152 хуулийн этгээд хамрагдлаа. Дахин үнэлгээний дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2019 оны 04 дүгээр сарын 22-28 өдрийн хооронд нэгтгэн тулган баталгаажууллаа.

Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ:

Аймгийн хэмжээнд 315 нэгж талбарын 1,830,092.20 м.кв талбай бүхий газар эзэмших, ашиглах эрхийг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолд заасны дагуу үнэлж 6,559,167,928.80 төгрөгөөр санхүүгийн тайлан балансын эргэлтийн бус хөрөнгийн биет бус хөрөнгөнд тусгууллаа. Аймгийн төвийн Улиастай сумын нутаг дэвсгэрт газар эзэмшигч байгууллагууд 6 бүсэд, Тосонцэнгэл сумд 4 бүсэд, хуваагдан үнэлэгдсэн бол хөдөөгийн сумд 1 бүсийн итгэлцүүрээр үнэлгээ хийгдсэн болно.

Барилга байгууламжийн үнэлгээ:

2018 оны санхүүгийн тайлангийн барилга байгууламжийн ангилалд бүртгэлтэй 600 барилга, 8 инженерийн байгууламж, 176 нийтийн эзэмшлийн хөрөнгө нийт 827 нэр төрлийн хөрөнгийг үнэлж санхүүгийн тайланд тусгуулсан. 2016, 2017, 2018 онуудад шинээр бий болсон, Мэргэжлийн хяналтын газрын барилгын хяналтын улсын байцаагчийн цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүйг тодорхойлсон дүгнэлттэй, Сангийн сайдын баталсан үнэлгээний аргачлалд ороогүй 574 хөрөнгүүд үнэлгээнд хамрагдаагүй болно. 2018 оны санхүүгийн тайлангаар барилга байгууламжийн дансанд 109,694,659,056.48 төгрөгийн балансын үнэтэй хөрөнгө бүртгэгдээд байна.

2019 оны хагас жилийн байдлаар Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн харилцааны асуудал хэлэлцсэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 3 удаагийн хурлаар 7 тогтоол гарснаас Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх-2 тогтоол /3 байгууллагын 123,7 сая төгрөгийн хөрөнгө/, Худалдах хөрөнгийн доод үнэ тогтоох-2 тогтоол Хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгох-1 тогтоол /3 байгууллагын 39 сая төгрөгийн хөрөнгө/ Хөрөнгө актлах-1 тогтоол /5 байгууллагын 157,7 сая төгрөгийн хөрөнгө/ тус тус гарсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 02 сарын 27-ны өдрийн 03 дугаар тогтоолын дагуу орон нутгийн өмчит 3 байгууллагын 4 нэр төрлийн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдан борлуулж орлогыг аймгийн Төрийн сангийн өмч хувьчлалын дансанд төвлөрүүлэн ажиллаж байна.

Байгууллагын дотоод ажил

Төрийн албаны тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан Төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг шинээр байгуулан байгууллагын нийт албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан. Мөн байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж батлуулсан. Байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг шинээр батлагдсан хууль журмын дагуу шинэчлэсэн.

Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэж архивын улсын үзлэгт бэлдэх ажлын хэсэг болон байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссууд 2019 оны 05 сарын 10-31-ний өдрүүдэд 2018 оны архивлаагүй баримтуудыг архивлаж байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн.

Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн дагуу нийт албан хаагчид эмнэлгийн иж бүрэн үзлэг, шинжилгээнд 2019 оны 05 дугаар сард хамрагдсан. Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төвийн фитнесстэй хамтарч ажиллан байгууллагын 10 албан хаагч 2019 оны 05 сараас эхлэн фитнессээр хичээллэж эхэлсэн.

Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулж, байгууллагын хариуцсан ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, мод тарих үндэсний өдрөөр 10 ширхэг мод тарьж хариуцсан талбайн зүлэгжүүлэлтийг хийж албан хаагч бүр мод зүлгээ услах хуваарийн дагуу мод зүлгээ усалж, албан өрөөндөө ажилтан бүр цэцэг тарьж ургуулсан.

Албан хаагчдын 2019 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу мэргэжилтэн Г.Нармандах Ёс зүйн дүрэм, нягтлан бодогч Г.Дашбалжир санхүүгийн ил тод байдал сэдвээр сургалт зохион байгуулсан.

ХЯНАСАН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

Д.БАТМЭНД

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАГИЙН ДАРГА

Н.ЖИГЖИДДОРЖ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Н.ЦОГТСАЙХАН